



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэбулган сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2024/61-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.open.audit.mn

Архангай аймаг

2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Гэрээгээр аудит гүйцэтгэсэн:

“Шинжлэн магадлахуй ЭЗШ” ХХК

Захирал С.Оргил

Утас: 9919-7345

Цахим хаяг: shinjlenmagadlahui.ezsh.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.02.25 № 72
танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ХҮҮХДИЙН
3 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.ДЭНЗЭДМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэбулган сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрдэнэбулган сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэг нь нь 125 хүүхдийн хүчин чадалтай бөгөөд 2023 онд 125 хүүхэдтэйгээр үйл ажиллагаагаа явуулсан. Тайлант онд худалдан авсан 8,136.9 мянган төгрөг, БШУЯ-аас үнэ төлбөргүй хүлээн авсан 2,985.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 31.5 хувиар өссөн байна.

Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын үнэлгээний төвөөс багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр 3 дүгээр түвшинд үнэлэгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллага нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 үндсэн зорилтын хүрээнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг БШУГ-аас 100 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|-----------------------|------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>146,066,021,14</u> | <u>95,273,506,57</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 106,465,695,14 | 46,383,425,57 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 106,465,695,14 | 46,383,425,57 |
| 3121 | Төгрөг | 106,465,695,14 | 46,383,425,57 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 106,465,695,14 | 46,383,425,57 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 39,600,326,00 | 48,890,081,00 |
| 351 | Түүхий эд материал | 39,600,326,00 | 48,890,081,00 |
| 35130 | Барилгын засварын материал | 137,500 | 3,066,750,00 |
| 354 | Хангамжийн материал | 39,600,326,00 | 48,890,081,00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 271,000 | 214,500 |
| 35420 | Аж ахуйн материал | 38,422,346 | 45,401,531 |
| 35460 | Хүнсний материал | 769,480,00 | 207,300,00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>33,370,076,86</u> | <u>36,410,565,85</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 33,370,076,86 | 36,410,565,85 |
| 392 | Биет хөрөнгө | 32,681,951,86 | 36,260,565,85 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,000,000,00 | 3,000,000,00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,725,000,00) | (1,837,500,00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 69,325,881,00 | 80,447,861,00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (48,498,841,44) | (53,079,757,65) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 43,891,310,31 | 43,891,310,31 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (34,826,008,01) | (37,675,957,81) |
| 39217 | Ном | 1,514,610,00 | 1,514,610,00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 688,125,00 | 150,000,00 |
| 39301 | Програм хангамж | 2,267,500,00 | 2,267,500,00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,579,375,00) | (2,117,500,00) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>179,436,098,00</u> | <u>131,684,072,42</u> |
| | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | <u>2,200,792,50</u> | 0 |
| | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 2,200,792,50 | 0 |
| 413 | Өглөг | 2,200,792,50 | 0 |
| 4136 | Бусад өглөг | 2,200,792,50 | 0 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 2,200,792,50 | 0 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>177,235,305,50</u> | <u>131,684,072,420</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 177,235,305,50 | 131,684,072,42 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 15,879,574,60 | 15,879,574,60 |
| 51101 | Өмч: - төрийн | 15,879,574,60 | 15,879,574,60 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 159,807,893,85 | 114,256,660,77 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 159,807,893,85 | 159,807,893,85 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (45,551,233,08) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,547,837,05 | 1,547,837,05 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>179,436,098,00</u> | <u>131,684,072,42</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | /Төгрөгөөр/ | |
|------------|--|------------------------------|-------------------------------|
| | | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 567,098,194,42 | 432,516,000,00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 80,993,594,42 | 9,102,000,00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 80,993,594,42 | 9,102,000,00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 41,156,457,42 | 8,952,000,00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 39,837,137,00 | 150,000,00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 486,104,600,00 | 423,414,000,00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 423,768,800,00 | 375,741,000,00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 423,768,800,00 | 375,741,000,00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 62,335,800,00 | 47,673,000,00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 62,335,800,00 | 47,673,000,00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 389,862,888,92 | 478,067,233,08 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 389,862,888,92 | 478,067,233,08 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 380,231,945,07 | 469,882,538,20 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 249,620,124,36 | 330,202,547,09 |
| 210101 | Үндсэн цалин | 214,426,198,36 | 239,035,037,53 |
| 210102 | Нэмэгдэл | 30,226,367,00 | 70,908,180,18 |
| 210104 | Урамшуулал | 4,967,559,00 | 20,259,329,38 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 31,603,666,00 | 36,231,794,18 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,498,336,91 | 24,704,693,92 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,528,461,85 | 2,881,208,57 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,022,758,29 | 2,304,906,81 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 504,839,60 | 578,768,24 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,049,269,35 | 5,762,216,64 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 36,184,423,15 | 40,147,440,92 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,495,233,15 | 5,824,857,92 |
| 210302 | Түлш, халаалт | 27,196,647,00 | 27,196,233,00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,492,543,00 | 7,126,350,00 |
| 2105 | Нормативт зардал | 38,668,191,00 | 43,788,230,00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,152,860,00 | 0 |
| 210502 | Хоол, хүнс | 37,515,331,00 | 43,788,230,00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,243,750,00 | 2,120,750,00 |
| 210604 | Урсгал засвар | 4,243,750,00 | 2,120,750,00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 597,000,00 | 385,000,00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 597,000,00 | 385,000,00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,314,790,56 | 17,006,776,01 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,351,030,00 | 7,028,585,00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,877,480,00 | 1,896,700,00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 12,086,280,56 | 8,081,491,01 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 9,630,943,85 | 8,184,694,88 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 7,210,600,00 | 6,659,135,80 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,210,600,00 | 6,659,135,80 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,420,343,85 | 1,525,559,08 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,420,343,85 | 1,525,559,08 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>177,235,305,50</u> | <u>(45,551,233,08)</u> |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>177,235,305,50</u> | <u>(45,551,233,08)</u> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| | | | /Төгрөгөөр/ |
|------------|--|-----------------------|------------------------|
| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>486,104,600.00</u> | <u>423,414,000.00</u> |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 486,104,600,00 | 423,414,000,00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 423,768,800,00 | 375,741,000,00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 423,768,800,00 | 375,741,000,00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 62,335,800,00 | 47,673,000,00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 62,335,800,00 | 47,673,000,00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>375,339,004.86</u> | <u>481,326,289.75</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 375,339,004,86 | 481,326,289,57 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 366,429,080,51 | 473,141,594,69 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 249,129,049,36 | 332,403,339,59 |
| 210101 | Үндсэн цалин | 192,536,620,36 | 233,255,805,69 |
| 210102 | Нэмэгдэл | 42,841,549,00 | 78,888,204,52 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | - |
| 210104 | Урамшуулал | 13,750,880,00 | 20,259,329,38 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 30,614,968,00 | 36,231,794,18 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,731,583,44 | 24,704,693,92 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,163,299,03 | 2,881,208,57 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,791,563,43 | 2,304,906,81 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 523,175,64 | 578,768,24 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,405,346,44 | 5,762,216,64 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 36,184,423,15 | 40,247,440,92 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,495,233,15 | 5,824,857,92 |
| 210302 | Түлш, халаалт | 27,196,647,00 | 27,196,233,00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,492,543,00 | 7,226,350,00 |
| 2105 | Нормативт зардал | 37,469,880,00 | 43,226,050,00 |
| 210502 | Хоол, хүнс | 37,469,880,00 | 43,226,050,00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,549,500,00 | 5,050,000,00 |
| 210604 | Урсгал засвар | 3,549,500,00 | 5,050,000,00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 592,000,00 | 385,000,00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 592,000,00 | 385,000,00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,889,260,00 | 15,597,970,00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,889,260,00 | 13,372,870,00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,000,000,00 | 2,225,100,00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 8,909,924,35 | 8,184,694,88 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 6,489,580,50 | 6,659,135,80 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,489,580,50 | 6,659,135,80 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,420,343,85 | 1,525,559,08 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,420,343,85 | 1,525,559,08 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>110,765,595.14</u> | <u>(57,912,289.57)</u> |

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|--------|---|-----------------------|-----------------------|
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 4,299,900,00 | 2,169,980,00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 4,299,900,00 | 2,169,980,00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 4,299,900,00 | 2,169,980,00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 4,299,900,00 | 2,169,980,00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>(4,299,900,00)</u> | <u>(2,169,980,00)</u> |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 106,465,695,14 | (60,082,269,57) |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 106,465,695,14 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 106,465,695,14 | 46,383,425,57 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | /Төгрөгөөр/ |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| | | | | | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
| C01 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 15,879,574,60 | - | 65,544,435,30 | 81,424,009,90 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 15,879,574,60 | - | 65,544,435,30 | 81,424,009,90 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 9,692,473,81 | -9,692,473,81 |
| C08 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 15,879,574,60 | 1,547,837,05 | 159,807,893,85 | 177,235,305,50 |
| D01 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 15,879,574,60 | 1,547,837,05 | 159,807,893,85 | 177,235,305,50 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 15,879,574,60 | 1,547,837,05 | 159,807,893,85 | 177,235,305,50 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | -45,551,233,08 | -45,551,233,08 |
| D09 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 15,879,574,60 | 1,547,837,05 | 114,256,660,77 | 131,684,072,42 |

ТГ

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Хувь | /Төгрөгөөр/ |
|--------|--|----------------|----------------|-----------------|-------|-------------|
| | | | | | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 106.465.695.14 | -106.465.695.14 | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 529,878,900,00 | 473,202,929,57 | 56,675,970,43 | 84.4 | |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 529,878,900,00 | 473,202,929,57 | 56,675,970,43 | 84.4 | |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 522,612,500 | 465,018,234,69 | 57,594,265,31 | 84.4 | |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 366,727,700,00 | 332,403,339,59 | 34,324,360,41 | 90,6 | |
| 210101 | Үндсэн цалин | 246,019,900,00 | 241,235,830,03 | 4,784,069,97 | 98,1 | |
| 210102 | Нэмэгдэл | 107,562,300,00 | 70,908,180,18 | 36,654,119,82 | 65,9 | |
| 210104 | Урамшуулал | 13,145,500,00 | 20,259,329,38 | -7,113,829,38 | 154,1 | |

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | |
|----------|--|----------------|----------------|---------------|-------|
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 46,241,000,00 | 36,231,794,18 | 10,009,205,82 | 78,4 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,572,000,00 | 24,704,693,92 | 6,867,306,08 | 78,2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,667,400,00 | 2,881,208,57 | 786,191,43 | 78,6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,933,900,00 | 2,304,906,81 | 628,993,19 | 78,6 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 733,400,00 | 578,768,24 | 154,613,76 | 78,9 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,334,300,00 | 5,762,216,64 | 1,572,083,36 | 78,6 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 41,773,000,00 | 40,247,440,92 | 1,525,559,08 | 96,3 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,959,000,00 | 5,824,857,92 | 1,134,142,08 | 83,7 |
| 210302 | Түлш, халаалт | 27,196,000,00 | 27,196,233,00 | -233,00 | 65,6 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,618,000,00 | 7,226,350,00 | 391,650,00 | 94,9 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | | | |
| 2105 | Нормативт зардал | 44,205,600,00 | 43,226,050,00 | 979,550,00 | 97,8 |
| 210502 | Хоол, хүнс | 44,205,000,00 | 43,226,050,00 | 979,550,00 | 97,8 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,900,000,00 | 5,900,000,00 | 0 | 100,0 |
| 210604 | Урсгал засвар | 5,900,000,00 | 5,900,000,00 | 0 | 100,0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | | | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 745,400,00 | 385,000,00 | 360,400,00 | 51,7 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 745,400,00 | 385,000,00 | 360,400,00 | 51,7 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,019,800,00 | 6,624,610,00 | 10,395,190,00 | 38,9 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,784,000,00 | 4,399,510,00 | 10,384,490,00 | 29,8 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,235,800,00 | 2,225,100,00 | 10,700,00 | 99,5 |
| 2109 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 7,266,400,00 | 8,184,694,88 | -918,294,88 | 112,6 |
| | Бусад урсгал шилжүүлэг | 7,266,400,00 | 6,659,135,80 | 607,264,20 | 91,6 |
| | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 7,266,400,00 | 6,659,135,80 | 607,264,20 | 91,6 |
| | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас төвлөрүүлэх шилжүүлэг | | 1,525,559,08 | -1,525,559,08 | |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 423,414,000,00 | 423,414,000,00 | | 100,0 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 375,741,000,00 | 375,741,000,00 | | 100,0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 375,741,000,00 | 375,741,000,00 | | 100,0 |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 47,673,000,00 | 47,673,000,00 | | 100,0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 47,673,000,00 | 47,673,000,00 | | 100,0 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | | | | |
| 120004 2 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | | | |
| 120004 3 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | | | | |

| | | | | | |
|----|---|-----|----------------|-----------------|-------|
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 106,465,695,41 | -106,465,695,14 | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 46,383,425,57 | -46,383,425,57 | |
| 2 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | 0.00 | 100.0 |
| 3 | Төсвийн байгууллага | 1 | 1 | 0.00 | 100.0 |
| 5 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 21 | 21 | 0.00 | 100.0 |
| 6 | Удирдах ажилтан | 1 | 1 | 0.00 | 100.0 |
| 7 | Гүйцэтгэх ажилтан | 10 | 10 | 0.00 | 100.0 |
| 8 | Үйлчлэх ажилтан | 10 | 10 | 0.00 | 100.0 |
| 10 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | 120 | 120 | 0 | 100,0 |
| 15 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 1 | 2 | 0.00 | 100.0 |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,269.9 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэнд зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитаар залруулагдаагүй 2 зөрчилтэй асуудал илэрсэн нь тогтоосон материаллаг байдлын дүн 3,709.1 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

3.1 Зөвлөмж

3.1.1 Хөрөнгө бэлтгэхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллага нь төсвийн хөрөнгөөр 2,169,980.00 төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авахдаа аймгийн ОНӨГ-аас зөвшөөрөл аваагүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.2. Төсөвт хуулийн этгээд нь Төсвийн тухай хуулийн батлагдсан урсгал төсөв, нэмэлт төсөв, хэмнэсэн төсөв болон давсан орлогоос үндсэн хөрөнгө бэлтгэх бол хэрэгцээ, шаардлагаа тодорхойлж, зайлшгүй хэрэгцээтэй хөрөнгийн жагсаалт, тоо хэмжээ, худалдан авах үнийн дээд хязгаарын саналыг дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагч дэмжсэн тохиолдолд Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зөвшөөрөл олгоно" гэсэн заалтыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгөөр хөрөнгө бэлдэхдээ холбогдох байгууллагаас зөвшөөрөл авах

3.1.2 Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цэвэр бохир усны зардлаас 100.0 мянган төгрөгөөр бараа материал худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Зөрчлийг давтан гаргахгүй байх

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 03 дугаар сарын 22-ны дотор ирүүлнэ үү.

Зөвлөмжийн биелэлтийг тооцож, нотлох баримтыг хангуулан 2024 оны 06 дугаар сарын 20-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|-------------|---------|---------------|-----|-----------------|-----|---------|---------|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Үндсэн хөрөнгө худалдан авахдаа ОНӨГ-аас зөвшөөрөл аваагүй байна. | 1 | 2,169.9 | | | | | 1 | 2,169.9 | | | | |
| Тогтмол зардлаас БМ худалдан авсан | 1 | 100.0 | | | | | 1 | 100.0 | | | | |
| Дүн | 2 | 2,269.9 | | | | | 2 | 2,269.9 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Хугацаа хоцроосон | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Дүн | 1 | 0 | | | | | 1 | 0 |